




ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БА ЭРГЭН ТӨЛӨЛТ

Зээлийн гэрээ гэдэг нь: зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан мөнгийг тохирсон хугацаанд, хүүтэй буцаан өгөх үүргийг тусгасан баримт бичиг юм.

Зээлийн бүтээгдэхүүний талаар дэлгэрэнгүй СУДЛАХ



Яаран гарын үсэг зурахаас өмнө зээлийн гэрээгээ сайтар УНШИХ



ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Ойлгохгүй заалтын талаар банкны ажилтнаас зөвлөгөө аваарай.



Эргэн төлөлтийн хуваарь нь ирээдүйн орлоготой уялдаж байгаа эсэхийг НЯГТЛАХ

Хүүгийн төлбөр болон гэрээний хариуцлагын талаарх заалтыг АНХААРАХ


Зээлийн эргэн төлөлтөө:

15–90 хоног хэтрүүлсэн бол : **анхаарал хандуулах буюу хугацаа хэтэрсэн**
91–180 хоног : **хэвийн бус**
181–360 хоног: **эргэлзээтэй**
361–ээс дээш хоног хэтрүүлсэн бол **муу зээл** болно.



“Хэрхэн ухаалаг зээл авах” талаар **ЗУРАГТ ХУУДАС №1–ээс** мэдээлэл аваарай.

“Хар жагсаалт” буюу “Зээлийн мэдээллийн сан”–д **хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлүүд** бүртгэгддэг ба зээлээ барагдуулж дууссанаас хойш **6 жилийн хугацаанд** бүртгэлтэй хэвээр байдаг.



Бүх санхүүгийн байгууллагууд нэгдсэн **зээлийн мэдээллийн сангаас** таны мэдээллийг авдаг гэдгийг санаарай.

ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР



■ Зээл

■ Хүүгийн төлбөр


1-р сар

2-р сар сүүлийн сар

01

Сар бүрийн тэнцүү төлбөр


/тогтмол цалинтай болон тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



02

Сар бүр тэнцүү үндсэн зээлийн төлбөр

/тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



03

Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлээ хувааж төлөх

/улирлын шинж чанартай тогтмол бус орлоготой бизнес эрхлэгчдэд/



04

Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, бусад хугацаанд зээлийн төлбөр тэнцүү

/улирлын шинж чанартай тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/

